

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2025 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/017-НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Ч.Сугардорж Утас: 7036-2442 Цахим хаяг: Sugardorjch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ОРОН СУУЦ” ОНӨААТҮГ
-ЫН ЗАХИРАЛ Г.ЗОЛБОО ТАНАА

2026.03.12 № СЭА-2026/017-НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь аймгийн Засаг даргын А/07 захирамжаар 2025 оны орлого, зарлагын төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын орон сууцны зээлийн 611,760.1 мянган төгрөг, сумдад хэрэгжсэн орон сууцны зээлийн 60,243.9 мянган төгрөг, АХС-ийн зээлийн 150,000.0 мянган төгрөг буюу нийт 822,004.0 мянган төгрөгийн авлага барагдуулахаар баталсан байна. Гүйцэтгэлээр төрийн албан хаагчдын орон сууцны зээлийг 750,450.3 мянган төгрөг, сумдад хэрэгжсэн орон сууцны зээлийг 79,626.7 мянган төгрөг, АХС-ийн зээлийг 142,702.8 мянган төгрөг буюу нийт 972,779.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж төлөвлөгөөг 22.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ нь тайлант онд 349,169.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэн 176,894.6 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, 172,275.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь тайлант онд 2 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 87.9 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь *(Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл)* санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Үлдэгдэл	
			01-р сарын 01	12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ			
1.1	Эргэлтийн хөрөнгө			
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	3,369,579,006.0	4,514,634,105.2
1.1.4.1	Дансны авлага		2,045,476,567.2	1,215,399,534.0
1.1.4.2	Бусад авлага		975,553,172.8	832,412,806.4
1.1.9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-	-
1.1.10	Бараа материал	6	-	226,650.0
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн		6,390,608,746.0	6,562,673,095.6
1.2	Эргэлтийн бус хөрөнгө			
1.2.1	Үндсэн хөрөнгө	7	30,284,039.0	30,284,039.0
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл		-15,469,091.7	-20,221,179.7
1.2.4	Программ хангамж		1,320,000.0	1,320,000.0
1.2.5	Хуримтлагдсан элэгдэл		-440,000.0	-880,000.1
1.2.6	Бусад биет бус хөрөнгө		668,076,000.0	668,076,000.0
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		683,770,947.2	678,578,859.2
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		7,074,379,693.2	7,241,251,954.8
2	Эргэлтийн бус хөрөнгө			
2.1	ӨР ТӨЛБӨР			
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	9		
2.1.1.3	Ажилчидтай холбоотой өглөг			202,003.0
2.1.1.4	Татварын өглөг /ТӨҮГ/		1,087,070.2	11,382,863.2
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,087,070.2	11,584,866.2
2.1.2	Урт хугацаат өр төлбөр			
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг			-
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
2.1.2.20	Цэвэр хөрөнгө өмчийн дүн		7,073,292,623.0	7,229,667,088.6
2.2.1	Өмч : а) төрийн		908,960.0	908,960.00
2.2.3	в)ТӨҮГ		5,006,136,572.2	5,006,136,572.2
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)		2,066,247,090.8	2,222,621,556.4
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		7,074,379,693.2	7,241,251,954.8

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх тайлант үеийн дүн	Тайлант улирлын дүн
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2		
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			
3	Нийт ашиг (алдагдал)			
4	Түрээсийн орлого			
5	Хүүний орлого		194,250,640.9	333,915,704.0
6	Ногдол ашгийн орлого			
7	Алдангийн орлого			15,254,238.0
8	Бусад орлого		-	
9	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт			
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3	183,379,939.0	176,894,632.0
11	Санхүүгийн зардал		-	
12	Бусад зардал /ТӨҮГ/		1,087,070.2	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/			
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/			
16	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол		5,192,088.0	5,192,088.0
17	Бусад ашиг /алдагдал/			
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		10,870,701.9	172,275,310.0
19	Орлогын албан татвар		1,087,070.2	17,227,531.0
21	Татварын дараах ашиг (алдагдал)		4,591,543.7	149,855,691.0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		4,591,543.7	149,855,691.0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Нэмж төлөгдсөн капитал	Эзэмшигч-дийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 1-ний үлдэгдэл		5,007,045,532.2	2,068,174,321.7	7,075,219,853.9
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
4	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
5	Тайлант үеийн цэвэр ашиг			4,591,543.7	4,591,543.7
6	Ногдол ашиг				-
7	Гаргасан хувьцаат капитал				-
8	2024 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	-	5,007,045,532.2	2,072,765,865.4	7,079,811,397.6
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
10	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-

11	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
12	Тайлант үеийн цэвэр ашиг			149,855,691.0	149,855,691.0
13	Ногдол ашиг				-
14	Гаргасан хувьцаат капитал				-
15	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	5,007,045,532.2	2,222,621,556.4	7,229,667,088.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх тайлант үеийн дүн	Тайлант үеийн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	194,250,640.9	349,169,942.0
1.1	Мөнгөн орлогын дүн	194,250,640.9	349,169,942.0
1.1.1	Бусад мөнгөн орлого	194,250,640.9	349,169,942.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	183,379,939.0	176,894,632.0
1.2.1	Ажилчдад төлсөн	108,562,310.0	102,300,797.2
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	13,362,654.0	12,289,409.9
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	4,136,250.0	3,508,500.0
1.2.4	Багаж, техник, хэрэгсэл	-	935,000.0
1.2.5	Тавилга	-	-
1.2.6	Дотоод албан томилолт	-	1,700,000.0
1.2.8	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,900,000.0	11,990,000.0
1.2.9	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.10	Татварын байгууллагад төлсөн	-	5,604,667.8
1.2.11	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.12	Бусад мөнгөн зарлага	43,418,725.0	38,566,257.2
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,870,701.9	172,275,310.0
1.4	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,367,565,741.9	972,779,789.3
1.5	Мөнгөн орлогын дүн	1,367,565,741.9	972,779,789.3
1.6	Мөнгөн зарлагын дүн	25,080,440.0	-
1.6.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,760,440.00	
1.6.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.0	
1.6.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
1.6.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
1.6.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,367,565,741.9	972,779,789.3
1.7	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,342,485,301.9	972,779,789.3
1.8	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.9	Мөнгөн зарлагын дүн	-	-
1.9.1	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
1.20	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
1.21	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,378,436,443.9	1,145,055,099.2
1.22	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,991,542,562.2	3,369,579,006.0
1.23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,369,979,006.0	4,514,634,105.2

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дансны эхний үлдэгдэл	3,369,579,006.0	4,514,634,105.2	-1,145,055,099.2	134.0
2	Нийт орлого	922,004,051.0	1,321,949,731.2	-399,945,680.2	143.4
2.1	Борлуулалтын орлого	822,004,051.0	972,779,789.3	-150,775,738.3	118.3
2.2	АВЛАГА	822,004,051.0	972,779,789.3	-150,775,738.3	118.3
2.2.1	Төрийн албан хаагчдын орон сууцны зээлийн барагдуулалт	611,760,131.3	750,450,303.3	-138,690,172.0	122.7
2.2.2	Сумдад хэрэгжсэн орон сууцны зээлийн барагдуулалт	60,243,919.7	79,626,730.0	-19,382,810.3	132.2
2.2.3	Аймаг хөгжүүлэх сангийн авлага барагдуулалт	150,000,000.0	142,702,756.0	7,297,244.0	95.1
2.3	Үндсэн үйл ажиллагааны орлого	100,000,000.0	349,169,942.0	-249,169,942.0	349.2
2.3.1	Хүү, алдангийн орлого	100,000,000.0	349,169,942.0	-249,169,942.0	349.2
3	Нийт зарлагын дүн	3,593,295,215.5	176,894,632.0	3,416,400,583.5	4.9
3.1	Цалин нийгмийн даатгалын шимтгэл	176,614,455.5	114,590,207.1	62,024,248.4	64.9
3.2	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	156,990,627.1	102,300,797.2	54,689,829.9	65.2
3.2.1	Үндсэн цалин	92,692,936.6	63,329,343.9	29,363,592.7	68.3
3.2.2	Нэмэгдэл цалин	47,250,614.5	29,287,204.3	17,963,410.2	62.0
3.2.3	Урамшуулал	9,847,076.0	5,754,249.0	4,092,827.0	58.4
3.2.4	Унаа хоол	7,200,000.0	3,930,000.0	3,270,000.0	54.6
3.3	Ажил олгогчоос төлөх НДШ/12.5%	19,623,828.4	12,289,409.9	7,334,418.5	62.6
4.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,416,680,760.0	62,304,424.9	3,354,376,335.1	1.8
4.1.1	Бичиг хэрэг	5,600,000.0	2,528,850.0	3,071,150.0	45.2
4.1.2	Тээвэр шатахуун	18,000,000.0	11,990,000.0	6,010,000.0	66.6
4.1.3	Сургалт семинарын зардал	2,000,000.0	120,000.0	1,880,000.0	6.0
4.1.4	Дотоод албан томилолт	6,000,000.0	1,700,000.0	4,300,000.0	28.3
4.1.5	Шуудан холбоо	1,200,000.0	663,850.0	536,150.0	55.3
4.1.6	Бага үнэтэй ТҮЭ	2,500,000.0	979,650.0	1,520,350.0	39.2
4.1.7	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,500,000.0	400,000.0	2,100,000.0	16.0
4.1.8	Техник, тоног төхөөрөмж	10,000,000.0	935,000.0	9,065,000.0	9.4
4.1.9	Ашиглалтын зардал /байрны түрээс/	1,200,000.0	1,000,000.0	200,000.0	83.3
4.1.10	Газрын төлбөр	6,680,760.0	6,355,290.0	325,470.0	95.1
4.1.11	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	3,361,000,000.0	35,631,784.9	3,325,368,215.1	1.1
4.1.12	Төсөл хөтөлбөрийн зардал /Орон сууц/	-	-	-	-
5	Нийт ажиллагсдын тоо	5.0	3.0	2.0	60.0
5.1	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
5.2	Мэргэжилтэн	2.0	1.0	1.0	50.0
5.3	Нягтлан бодогч	1.0	1.0	-	100.0
5.4	Архив, бичиг хэрэг	1.0	-	1.0	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **7,940.1** мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,940.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 22,270.2 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага:

1. Аймаг хөгжүүлэх сангийн авлага барагдуулах орлогын төлөвлөгөөг 7,297.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь *"Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"*, Аймгийн Засаг даргын 2025 оны А/07 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт "Сэлэнгэ орон сууц" ОНӨААТҮГ-ын 2025 оны орлого, зарлагын төлөвлөгөө 2.2.3 дахь *"Аймаг хөгжүүлэх сангийн авлагын барагдуулалт"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй 642.9 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг тайлант онд суутган тооцсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх *"Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно"*, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ"*, 14.4.2 дахь *"бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"* заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй.	1	7,297.2			1	7,297.2						
Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй авлага барагдуулсан.	1	642.9			1	642.9						
Дүн	2	7,940.1			2	7,940.1						